

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлд:

“XII.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Сангийн сайд Ж.Эрдэнэбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

2.1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:

2.1.1. шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан тайланг улирал тутам гаргаж Сангийн яаманд хүргүүлж, холбогдох мэдээллийг цахим хуудсандаа тогтоосон хугацаанд байршуулж байх;

2.1.2. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу харьяа байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

2.2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг боловсронгуй болгон мэдээлэл оруулах, мэдээллийг шууд хөрвүүлэн тавих нөхцөлийг бүрдүүлж, цаашид шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутам Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд Ж.Эрдэнэбатад даалгав.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР